



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайвны өргөн чөлөө 16, Засгийн газрын IX байр,
Утас/Факс: (976-51) 26 23 50, И-мэйл: info@pcsp.gov.mn,
Вэбсайт: www.pcsp.gov.mn

2021.11.29 № А-1/1947
танай _____-ны № _____-т

**"МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ"
ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ
ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ч.ЗОЛБАЯР
ТАНАА**

Зөвшөөрөл олгох тухай

Танай байгууллагаас ирүүлсэн үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах, зөвшөөрөл хүссэн 2021 оны 1/307 дугаар албан бичигтэй танилцлаа.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 2.1 дэх заалтыг үндэслэн "Мэдээлэл холбооны сүлжээ" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, цаашид ашиглах боломжгүй болох нь тогтоогдсон, 585 нэрийн нийт 391,672,688.14 (гурван зуун ерэн нэгэн сая зургаан зуун далан хоёр мянга зургаан зуун наян найман төгрөг арван дөрвөн мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрч байна.

Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгийг акталж, устгах, ашиглаж болох материалыг ялган тоолж сэлбэгээр ашиглах, хоёрдогч түүхий эдээр худалдан борлуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хөрөнгийн хөдлөлийг нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэхийг мэдэгдье.

Хавсралт 12 хуудастай

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

132008467

A-4/2021



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 522

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2, 6.3.4, 6.4.3, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Мэдээлэл холбооны сүлжээ" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 726 нэрийн нийт 5,063,281,455.18 (таван тэрбум жаран гурван сая хоёр зуун наян нэгэн мянга дөрвөн зуун тавин таван төгрөг арван найман мөнгө) төгрөгийн балансын үнэ, 4,970,438,690.52 (дөрвөн тэрбум есөн зуун далан сая дөрвөн зуун гучин найман мянга зургаан зуун ерэн төгрөг тавин хоёр мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. "Мэдээлэл холбооны сүлжээ" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Ч.Золбаярт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, ашиглаж болох материалыг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар ашиглах, худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3 Хөрөнгө акталж, чөлөөлөгдсөн газрыг компанийн мэдэлд хэвээр үлдээж, зориулалтын дагуу ашиглах, нөхөн сэргээх ажлыг зохион байгуулах;

2.4 Арга хэмжээний биелэлтийн хамт 2022 оны 1 дүгээр улиралд багтаан тайлагнах.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001587